



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 7/293

Хэрлэн сум

Бог малын мялзан өвчнөөс
урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын
ажлыг зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 29.1.6-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг тарилга хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Уг вакцинжуулалтын ажилд багийн Засаг дарга, төрийн албан хаагчдыг томилон түргэн шуурхай, чанартай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж, тарилгын дүн, санхүүжилтийн баримт материалыг холбогдох яаманд хүргүүлж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуй газар /Ж.Энх-Амгалан/-т, вакцинжуулалтын чанар, явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА